

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН 2019 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2019.11.29

Сүхбаатар сум

Д/д	Зорилт	Хэрэгжүүлэх арга зам	Гүйцэтгэлийн үзүүлэлт
1	2	3	5
1	Төрийн захиргааны албан хаагчийн “Ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтэнд хяналт тавих	<p>Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 01 сарын 23 өдрийн 33 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг МХГ-ын нийт ажилтан, албан хаагчдад танилцуулж, гарын үсэг зуруулна.</p> <p>Байгууллагын ёс зүйн зөвлөлийн ажлын 2019 оны төлөвлөгөөг хэлэлцэн боловсруулж, ажилтан албан хаагчдад танилцуулна.</p> <p>МХГ-ын үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, ёс зүйн хэм хэмжээ зөрчигдөхөөс сэргийлсэн ёс зүйн сургалт, мэдээлэл хийнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн хяналтын газрын Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, байгууллагын нийт ажилтан, албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/09 тоот тушаалаар Ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгууллаа. - Байгууллагын ёс зүйн зөвлөл нь Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 01 сарын 23 өдрийн 33 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг байгууллагын ажилтан, албан хаагчдад тайлбарлан таниулж, цаашид ёс зүйн зөрчилгүй ажиллахыг анхааруулсан зөвлөмж зааварчилгаа өглөө. - Мөн байгууллагын нийт ажилтан албан хаагчид ёс зүйн дүрэмтэй танилцсан тухай гарын үсэг зуруулсан болно. - Ёс зүйн зөвлөлийн ажлын 8 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулж батлуулан цаашид төлөвлөгөөний дагуу авч хэрэгжүүлэх ажлын талаар нийт ажилтан, албан хаагчдад танилцуулж санал хүсэлтийг сонслоо. - Монгол улсын Засгийн газрын 33 тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын ёс зүйн дүрэм”-ийг байгууллагын нийт ажилтан албан хаагчдад танилцуулж гарын үсэг зуруулан ажилаллаа. - Мөн “Харицаа”, “Ёс суртахуун” сэдвээр нийт ажилтан албан хаагчдад мэдээлэл хийж харьцаа хандлагаа өөрчлөх, байгууллагад байгаа бодит харицааны талаар тайлбарлан таниулж, цаашид хэрхэн ёс зүйтэй, эерэг уур амьсгалыг бүрдүүлэх талаар мэдээлэл өглөө. Сургалт мэдээллийн цагаар байгууллагын нийт

			<p>ажилтан, албан хаагчаас манай байгууллагад ёс зүйн зөрчил байгаа эсэх, ёс зүйн зөрчил байгаа бол юунаас шалтгаалж байгаа болон харицаа хандлагаа зайлшгүй засах шаардлагатай албан хаагчийн талаар санал асуулга авлаа. Санал асуулгад 34 албан хаагч буюу нийт ажилтны 87.1% хамрагдлаа. Үүнээс: Манай байгууллагад ёс зүйн зөрчил байхгүй гэж - 29.4%, ёс зүйн зөрчил байгаа 70.5% нь хариулсан байлаа.</p> <p>Ёс зүйн зөрчил гарч байгаа шалтгаанаа:</p> <ul style="list-style-type: none"> - Ажилтан, албан хаагчдын хоорондын харицаа хандлага , үл ойлголцол - 47.8% - Бил гэсэн үзэлтэй, байцаагч гэсэн хандлагатай, бусдаас үг сонсож чаддаггүй- 17.3% - Бусдын нэр хүндэд нөлөөлөх, мэдээлэл бүгдэд очоогүй -8.6% - Ёс зүйн зөрчил гаргаж байгаагаа өөрөө ч ойлгодоггүй, бусдад зөв үлгэр дууриал болж чаддаггүй, ажил үүргээ биелүүлдэггүй, соёлгүй, ёс хонзонгийн байдалтай - 4.3% гэж хариулсан байлаа. - Манзан авир харьцаа хандлагаа зайлшгүй засах шаардлагатай хүн гэсэн санал асуулгад зарим улсын байцаагчид 12-37% санал авсан нь цаашид харьцаа хандлагаа засах шаардлагатайг харууллаа. <ul style="list-style-type: none"> - 2019 оны 02 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд улсын байцаагчдын нэгдсэн XI зөвлөгөөнөөр “Хууль сахин мөрдөлтийн соёлыг төлөвшүүлье” уриатайгаар зохион байгуулж дотоод зохион байгуулалтыг сайжруулах, албан хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх талаар мэдээлэл авсан. - Зөвлөгөөний үеэр Ёс зүйн хорооны гишүүн Т.Биндэръяа /Хүний нөөц, эрх зүйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн/ албан хаагчдад ёс зүйн талаар мэдээлэл хийлээ. - Улсын байцаагчдаар 2019 онд “Ёс зүйн зөрчилгүй ажиллах” баталгаа гаргуулж гарын үсэг зуруулан, хяналт шалгалтын явцад олж мэдсэн авилгатай холбоотой асуудлыг Авилгатай тэмцэх газар мэдээлж байх үүрэг даалгаврыг өгч ажиллалаа.
--	--	--	--

4		<p>Байгууллагын хамт олныг идэвхижүүлэх, соён гэгээрүүлэх зорилгоор биеийн тамир, урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулж ажлын бүтээмжийг нэмэгдүүлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - 2019 оны 11 сард байгууллагын ажилтан албан хаагчдыг хамарсан буухай тэмцээнийг зохион байгуулж ажилаллаа. Энэ арга хэмжээ нь албан хаагчдын чөлөөт цагийн зөв боловсон өнгөрүүлэх, нэг баг болон санаа бодлоо хуваалцан, нэгэн зорилгын төлөө хамтран ажиллах, биесээ дэмжих, хүндэтгэх аргыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ байлаа.
5		<p>Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн 1.3-д заасны дагуу удирдах албан тушаалтан хариуцсан салбар нэгжид ажиллаж байгаа төрийн албан хаагчийн ёс зүйн байдалд хяналт тавьж, дүрмээр хүлээсэн хэм хэмжээг сахин мөрдөх нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй гэсэн заалтын хүрээнд ажилтан албан хаагчдад соён гэгээрүүлэх сургалт, мэдээлэл хийнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга, дотоод зохион байгуулалтыг сайжруулах талаарх сургалтыг Төрийн захиргаа эрсдлийн удирдлагын хэлтсийн дарга Д.Баттүвшин нийт ажилтан албан хаагчдад мэдээлэл өглөө. - Ёс зүйн хэм хэмжээний талаар хэлтсийн дарга нар өөрийн хариуцсан хэлтсийн ажилтан, албан хаагч нарт соён гэгээрүүлэх мэдээллийг тухай бүр хийж, ёс зүйн зөрчил гаргасан ажилтан албан хаагчийн асуудлыг байгууллагын ёс зүйн зөвлөлд тухай бүр оруулж шийдвэрлүүллээ. Тухайлбал: - БОДБХХХ-ийн дарга Н.Эрдэнэцогт 2 улсын байцаагчийн ажил тасалсан асуудлыг, Эрүүл мэнд боловсрол, хүнсний хяналтын хэлтсийн дарга А.Бямбадорж албан ажилдаа хариуцлаггүй хандсан, ажлаа тасалсан 3 улсын байцаагчийн асуудлыг, Итгэмжлэгдсэн лабораторийн эрхлэгч И.Ургамалсайхан автоклавчин бүдүүлэг зан авир гаргасан асуудлыг тус тус Ёс зүйн зөвлөлд оруулж сануулах хариуцлага болон зөрчлийн шинж чанараас хамаарч газрын даргад асуудлыг оруулж сахилгын шийтгэл ноогдуулан ажилаллаа.
6		<p>Ёс зүйн зөвлөл нь Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн тухай иргэд, байгууллага, ААН-ийн гомдол, мэдээлэл, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд нийтлэгдсэн болон тухайн байгууллагын дотоод хяналтаар илэрсэн мэдээ, баримтыг шалгалт явуулах үндэслэл болгон ажилласан байна.</p>	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын ажилтан албан хаагч нартай холбоотой гаргасан иргэн болон хэлтсийн дарга нарын 8 гомдлыг шийдвэрлэн ажилаллаа. Тухайлбал: 2 албан хаагчид ёс зүйн уучлалт гуйлгуулах хариуцлага, 6 албан хаагчийн ёс зүйн зөрчил нь сахилгын шинж чанартай тул газрын даргад асуудлыг тавьж шийдвэрлүүллээ. - Ёс зүйн дүрмийн дагуу ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг тухайн төрийн албан хаагчийн хувийн хэрэгт тэмдэглэж, дотоод сүлжээнд байршуулан ажилаллаа.
7		<p>Ёс зүйн зөвлөлийн ажлын төлөвлөгөөний</p>	<ul style="list-style-type: none"> - 2019 оны 12 сарын 15 дотор МХЕГын ёс зүйн зөвлөлд

		гүйцэтгэлийг гаргаж МХЕГ-т хүргүүлнэ.	хүргүүллээ.
8		МХГ-ын ёс зүйн зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайланг нэгтгэж газрын дарга түүний зөвлөлд тайлагнаж, МХЕГ-т тайланг хүргүүлсэн байна.	- Ёс зүйн зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайланг МХГ-ын газрын даргын зөвлөлд танилцууллаа.